



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.01.10 № 01/48  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР,  
АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР, ТӨРИЙН  
АУДИТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ  
ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ  
ХИЙЖ БАЙГАА ХАРААТ БУС  
АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн аудитын байгууллагаас 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхэд анхаарах асуудлыг нэгтгэж, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар, төрийн аудитын байгууллагатай гэрээний үндсэн дээр санхүүгийн тайлангийн аудит хийж байгаа хараат бус аудитын хуулийн этгээдэд тус тус чиглэл болгон хүргүүлж байна

Аудитын явцад чиглэл болгосон асуудалд анхаарал хандуулж, хэрэгжүүлэхээс гадна Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем – програм хангамжийн ашиглалтыг сайжруулах, төлөвшүүлэх, хөгжүүлэх ажилд идэвх санаачилгатай ажиллахыг зөвлөж байна.

Аудитын явцад гарсан хүндрэлтэй асуудлыг тухай бүр шат шатандаа шийдвэрлэж, аудитыг тогтоосон хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд бүх хүч нөөцөө дайчлан ажиллана уу


Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

Үндэсний аудитын газрын 2019 оны  
1 дүгээр сарын 10-ны өдрийн 07/18  
Дугаар албан бичгийн хавсралт



Төрийн аудитын байгууллагаас 2018 оны санхүүгийн тайланд  
аудит хийхэд анхаарах асуудал

2019-01-09

Энэ тайлант хугацаанд төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитын талаар баримталж байгаа бодлого, чиглэлийг дараах байдлаар нэгтгэн хүргэж байна.

**Нэг. Санхүүгийн тайлангийн аудитын бодлого, арга зүйн талаар**

Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийх ажил харьцангуй төлөвшиж байгаа боловч сүүлийн жилүүдэд санхүүгийн тайлангийн аудитын бодлого, арга зүйг АДБОУС-т нийцүүлэх, түншийн үнэлгээ болон гадны шинжээч зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон ажил арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулан аудитад нэвтрүүлэх ажил үргэлжилж байна.

Энэхүү журмаар санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажил, түүний гүйцэтгэлийг баримтжуулах аудитын ажлын баримт материалын загвар маягтуудыг боловсруулж, ажлын баримт бэлтгэх зааварчилгааг баталгаажуулав.

Дээрх журам, маягт, зааварчилгааг санхүүгийн тайлангийн аудитад ашиглаж байгаа бусад журам, зааврын хамт эмхэтгэж, аудиторруудад хүргүүлэв.

Батлагдсан хуваарийн дагуу 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ анхаарах асуудлыг дараах байдлаар чиглэл болгон хүргүүлж байна. Үүнд:

**1. Ажлын баримт материал бэлтгэх талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитын батлагдсан журамд тусгасан хугацаатай үе шатны ажлуудыг тогтоосон хугацаанд нь хэрэгжүүлэхээр тооцож ажлаа төлөвлөж, зохион байгуулах шаардлагатай.

Журмын дагуу хийх үе шатны ажлуудыг батлагдсан ажлын баримтын загвар, холбогдох зааврын дагуу бэлтгэж баталгаажуулна.

Дээрх маягтууд нь үе шатны ажлыг нэгтгэсэн байдлаар баримтжуулах бөгөөд шаардлагатай бусад ажлын баримт материалыг өмнө хийж байсан туршлага, хэрэглэж байсан маягт аргачлалыг ашиглахаас гадна АДБОУС-ийг хэрэгжүүлэх гарын авлагаас загвар авч, ашиглаж болно. Шинээр боловсруулж байгаа ажлын баримтын нарийвчилсан загвар дээрх гарын авлагад үндэслэнэ.

Шинээр батлагдсан журамтай уялдуулан Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөө, тайлангийн загварыг Санхүүгийн аудитын иж бүрэн гарын авлага гартал урьдчилсан байдлаар боловсруулж, СТАУС-т оруулсан тул тэрхүү загварыг ашиглаж, аудитын төлөвлөгөө, тайланг баталгаажуулна. Ингэхдээ зарим зүйл заалтыг тухайн аудитын онцлогоос хамаарч засвар өөрчлөлт оруулж болно.

Хараат бус аудитын компаниар гэрээний үндсэн дээр хийлгэж байгаа аудитыг "Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах, гэрээ, байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам" болон бусад холбогдох журмын дагуу хяналт удирдлагаар хангаж, холбогдох ажлын баримт материалыг тухай бүр бүрдүүлж, баталгаажуулна.

## **2. Төрийн аудитын байгууллагаас 2018 - 2019 онд санхүүгийн тайлангийн аудит хийх бодлого, чиглэл**

Стратегийн удирдлагын газар Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 10.23-т заасны дагуу 2018 оны санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах нэгдсэн бодлого, чиглэлийг боловсруулж, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/157 дугаар тушаалаар батлуулав. Энэхүү бодлого, чиглэлийг аудит хийх явцдаа хэрэгжүүлж ажиллах бөгөөд үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийг хангах арга зам, нэгдсэн судалгааны маягтуудыг бэлтгэж тохируулга хийнэ.

Нэгдсэн судалгааны маягтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч, баталгаажуулан СТАУС програмын тайлагнах үе шатны "Тайлант хугацааны бодлого, зорилтын хэрэгжилт, үр дүн" гэсэн ажлын "холбогдох нотлох зүйл" хэсэгт хавсаргана. (Excel болон PDF хэлбэрээр)

## **3. Ажлын гүйцэтгэлийг үнэлэх талаар**

Төрийн аудитын байгууллагатай гэрээний үндсэн дээр санхүүгийн тайлангийн аудит хийж буй хараат бус аудитын хуулийн этгээдийн гэрээт ажлын гүйцэтгэлийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/64 дүгээр тушаалаар баталсан "Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал"-ын дагуу үнэлнэ.

Харин төрийн аудитын байгууллагын аудиторуудын аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх бодлого, арга зүйг Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 28 дугаар зүйлийн дагуу нарийвчлан боловсруулж байна.

Энэ ажлын хүрээнд аудиторуудын аудитын ажлын гүйцэтгэлийг энэ тайлант хугацаанд туршилтын журмаар цахим хэлбэрээр үнэлэхээр төлөвлөж, СТАУС-т тохируулга хийсэн байгаа.

Анхан шатны чанарын хяналт хариуцсан ажилтнууд СТАУС програм хангамж ажиглаж үе шатны ажил тус бүрд цахим хэлбэрээр үнэлгээ өгнө.

Энэ тайлант хугацааны хувьд шинэ журмаар тогтоосон хугацааг баримтлах боломжгүй байгаа тул ажлын гүйцэтгэлд аудит хийх хугацаатай холбоотой үзүүлэлтийг 100 гэж нийтэд нь тооцож байгаа болно.

## **Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитад СТАУС-ыг хэрхэн ашиглах талаар**

Цахим аудитын тогтолцоо бий болгох зорилтын хүрээнд СТАУС – програм хангамжийг төрийн аудитын байгууллага энэ жилээс системийн хэмжээнд ашиглахаар төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Програм хангамжийг шинээр батлагдсан журамтай уялдуулан тохируулга, шинэчлэл хийсэн бөгөөд 2018 оны санхүүгийн тайланд аудитын гүйцэтгэл, үр дүнг СТАУС-т оруулахдаа дараах асуудалд анхаарна уу. Үүнд:

- Аудитын хянан удирдлагатай холбоотой мэдээ мэдээллийг СТАУС-ийн "Мэдээ мэдээлэл" цэсээр дамжуулан өгч байгаа тул өгч байгаа чиглэл зааварчилгааг тогтмол харж, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллах
- СТАУС-т мэдээлэл оруулах зөвлөмж, чиглэл бэлтгэж, СТАУС-ын "Мэдээ мэдээлэл"-д оруулсан тул түүнийг аудитын явцад чиглэл болгож ажиллах

- Програм хангамжийн гарын авлагыг СТАУС-ын “Мэдээ мэдээлэл” цэсээс цахим хэлбэрээр татаж авч СТАУС-т мэдээлэл оруулахдаа ашиглах
- Үйлчлүүлэгч байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авч, тулгалт - шалгалт хийж байгаа үзүүлэлтүүдийг цаашид нэмэгдүүлэх тул өөрсдийн зүгээс шинээр нэмэх үзүүлэлтийг<sup>1</sup> холбогдох маягтын дагуу бүртгэн ирүүлж байх
- Аудитын эрсдэл, горимын санг баяжуулж, аудитад ашиглах зорилгоор энэ санд шинээр нэмэх саналыг холбогдох маягтаар байгууллагын хэмжээнд нэгтгэн ирүүлэх
- Төрийн аудитын байгууллагаас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт гаргах, нэгтгэх, батлах үйл ажиллагааг санхүүгийн аудитын програм хангамж ашиглан цахим хэлбэрээр хийнэ. Ингэхдээ СТАУС програм дахь Үйлчлүүлэгч байгууллагын талаарх мэдээллийн сан болон энэ жил хийж байгаа аудитын жагсаалтад үндэслэх бөгөөд тайлант хугацаанд нэмэгдсэн, хасагдсан байгууллагын талаарх мэдээллийг програмд нэмж оруулах замаар дээрх жагсаалтыг гаргана. Иймд СТАУС дээрх байгууллагын талаарх мэдээллийн иж бүрдэл, үнэн зөв байдлыг хангах нь зүйтэй байна.
- Санхүүгийн тайлан аудитын бодлого, арга зүй, СТАУС-ийн ашиглалтыг сайжруулах, төлөвшүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой ажил хэрэгч, санал зөвлөмжийг СТАУС-ийн “санал хүсэлт” хэсэгт оруулж байхыг зөвлөж байна. Бид цаашид энэ санал, зөвлөмжид тулгуурлан хөгжүүлэлтийг хийх тул энэ цэс бидний хувьд мэдээлэл солилцох гол суваг байх болно.

#### Стратегийн удирдлагын газар

---

<sup>1</sup> Загвар EXCEL-ийн хүрээнд тулгалт хийх үзүүлэлт